



**“ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛЭЭС**

2025 оны 03 сарын 18 өдөр

Дугаар 04

Хэрлэн сум

“Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн хурлын тэмдэглэлд:

ХЭЛЭЛЦСЭН нь:

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Дотоод аудиторын 2024 оны ажлын тайлангийн тухай

ТЭМДЭГЛЭСЭН нь:

Төлөвлөгөөг 6 бүлэг 21 заалттайгаар батлуулан, хэрэгжүүлж ажилласан. Гүйцэтгэл 61.9% байна. 2025 оны 1-р улирал, хагас жилд хийх 5 ажлыг 1, 2-р улиралд багтаан хийж гүйцэтгэнэ.

Эрсдэлийн үнэлгээ хийх ажлыг улсын комисс хүлээн авсны дараа хийх, дунд хугацааны төлөвлөгөөг компанийн зорилго, зорилт боловсруулсны дараа хийхээр төлөвлөсөн байна.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

“...Дотоод аудиторын 2024 оны ажлын тайланг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хороогоор хэлэлцүүлэн, дүгнэлт гаргуулж, дахин танилцуулахыг Дотоод аудитор Г.Ганбүргэд болон Аудитын хороо (Э.Ганбаатар)-д үүрэг болгосугай...” гэжээ.

ДАРГА



ХУЯГЦОГТ



“ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛЭЭС

2024 оны 06 сарын 24 өдөр

Дугаар 05

Хэрлэн сум

“Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн хурлын тэмдэглэлд:

ХЭЛЭЛЦСЭН нь:

Компанийн 2024 оны худалдан авах ажиллагаанд хийсэн дотоод аудиторын тайлан, дүгнэлт танилцуулах тухай

ТЭМДЭГЛЭСЭН нь:

Компанийн 2024 оны худалдан авах ажиллагаанд хийсэн тайланг Дотоод аудитор Г.Ганбүргэд танилцуулав.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

1.”...Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг ханган биелүүлэхийг Гүйцэтгэх захирал (Ө.Жаргалсайхан)-д үүрэг болгов.

2.Дотоод аудиторын 2024 оны худалдан авах ажиллагаанд хийсэн дотоод аудитын тайланд тусгагдсан алдаа, зөрчлийг арилгах, алдааг дахин давтахгүй байхад анхаарч, төлөвлөгөө гарган, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Ө.Жаргалсайхан)-д үүрэг болгов...” гэжээ.

ДАРГА



ОХУЯГЦОГТ



**“ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛЭЭС**

2025 оны 06 сарын 24 өдөр

Дугаар 06

Хэрлэн сум

“Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн хурлын тэмдэглэлд:

ХЭЛЭЛЦСЭН нь:

Компанийн 2024-2025 оны өвлийн их ачааллыг давсан тухай тайланг танилцуулах тухай

ТЭМДЭГЛЭСЭН нь:

Компани нь 2024 онд их засварын 5 багц ажил, ТЗБАХ-ний 2 багц ажил, Хөрөнгө оруулалтын 21 багц ажил төлөвлөн, нийт 28 багц ажлыг 3.3 тэрбум төгрөгөөр хийж гүйцэтгэсэн байна. Биелэлтийн хувь 100%.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

“...Компанийн 2025-2026 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлыг төлөвлөгөөний дагуу чанартай, хугацаанд нь шуурхай зохион байгуулж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Ө.Жаргалсайхан)-д үүрэг болгов...” гэжээ.

ДАРГА



О.ХУЯГЦОГТ



“ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 09 сарын 12 өдөр

Дугаар 07

Хэрлэн сум

“Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн хурлын тэмдэглэлд:

ХЭЛЭЛЦСЭН нь:

Компанийн 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан, техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэлийн тухай

ТЭМДЭГЛЭСЭН нь:

Компани 2025 оны эхний хагас жилд 195.1 сая.кВтц цахилгаан түгээж төлөвлөгөөнөөс 10.6 сая.кВтц-аар буурсан, 201.1 мян.Гкал дулааны эрчим хүч түгээж, төлөвлөгөөнөөс 8.2 мян.Гкал буюу 4.2%-аар давуулан биелүүлсэн байна.

2025 оны хагас жилд нийт 74,123.4 сая төгрөгийн зардал гаргаж, нийт 57,978.9 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, татварын дараа 16,144.5 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

“...Компанийн 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг бүрэн хангах, ашигт ажиллагаа, үр ашгийг дээшлүүлэх, авлагыг бууруулах, өр төлбөрийг тогтоосон хугацаанд нь барагдуулах талаар арга хэмжээг авч ажиллахыг Гүйцэтгэх захирал Ө.Жаргалсайханд даалгав...” гэжээ.

ДАРГА



О.ХУЯГЦОГТ



**“ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2025 оны 09 сарын 12 өдөр

Дугаар 08

Хэрлэн сум

“Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн хурлын тэмдэглэлд:

ХЭЛЭЛЦСЭН нь:

Компанийн 2025 оны худалдан авах төлөвлөгөөний эхний хагас жилийн биелэлтийн явцын тухай

ТЭМДЭГЛЭСЭН нь:

“Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК нь 2025 онд нийт 104 худалдан авалт хийхээр төлөвлөсөн.

Багцтай зарласан тендерийн 8 гэрээ нэмэгдэж 112 гэрээ байгуулахаас 89 гэрээ байгуулж, 47 гэрээг бүрэн дуусгаж дүгнэсэн. 16 гэрээ жилийн эцэс хүртэл болон бүтэн жилийн хугацаатай байгуулагдан хэрэгжиж байна.

4 тендерийг зогсоож, 2 тендерийг 3-5 удаа зарлаж оролцогч оролцоогүй учраас шалгаруулалт амжилтгүй болж Эрчим хүчний яаманд хүсэлт гарган 2025 оны төлөвлөгөөнөөс хасуулсан.

2025 оны 07 сарын 31-ний өдрийн байдлаар Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэлт 81.6% байна.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

“...Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг ханган биелүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирал Ө.Жаргалсайханд үүрэг болгов...” гэжээ.

ДАРГА  О.ХУЯГЦОГТ



**“ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2025 оны 09 сарын 12 өдөр

Дугаар 09

Хэрлэн сум

“Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн хурлын тэмдэглэлд:

ХЭЛЭЛЦСЭН нь:

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Дотоод аудиторын 2024 оны ажлын тайлангийн тухай

ТЭМДЭГЛЭСЭН нь:

Дотоод аудиторын 2024 оны ажлын тайланг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хороо хэлэлцэн, дүгнэлт гаргаж танилцуулав.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

“...Аудитын хорооноос өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийн тайланг нэгтгэн гаргаж, Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулах, цаашид зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Дотоод аудитор Г.Ганбүргэдэд үүрэг болгов ...” гэжээ.

ДАРГА



О.ХУЯГЦОГТ



**“ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2025 оны 09 сарын 12 өдөр

Дугаар 10

Хэрлэн сум

“Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн хурлын тэмдэглэлд:

ХЭЛЭЛЦСЭН нь:

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Дотоод аудиторын 2025 оны ажлын төлөвлөгөөний тухай

ТЭМДЭГЛЭСЭН нь:

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Дотоод аудитор 2025 оны ажлын төлөвлөгөөг Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд танилцуулав.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

“...Дотоод аудиторын ажиллах журмын 3.1-т “Дотоод аудитор нь компанийн зорилго, зорилт, аудитын нөөц, хэрэгцээ шаардлагатай уялдуулан тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах бөгөөд Аудитын хорооны саналыг үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга батална...” гэж заасны дагуу Дотоод аудиторын 2025 оны ажлын төлөвлөгөөг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга батлахыг хуралд оролцсон бүх гишүүд дэмжив...” гэжээ.

ДАРГА



О.ХУЯГЦОГТ